



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Энхтайваны өргөн чөлөө-57, 13 дугаар хороо,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330  
Утас/Факс: (976) 26-63-59  
<http://www.bzd.ub.gov.mn>

2019.05.31 № 02/1199  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Баянзүрх дүүргийн харьяа хэлтэс,  
Албадын дарга нарт


"Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе" уриатай хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх "Өгөөмөрөдөр" өдөрлөг 2019 оны 06 дугаар сарын 9-ний өдрийн Ням гаригт 11:00 цагаас 17:00 цагийн хооронд Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадна талбайд зохион байгуулагдана.

Уг өдөрлөгт иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг өргөнөөр оролцуулж, хуучин, гутал хувцас, цүнх, гоёл чимэглэл, электрон бараа, гэр ахуйн хэрэгсэл, ном, сэтгүүл, хүүхдийн тоглоом гэх мэт угааж цэвэрлэсэн болон дахин ашиглаж болохуйц эд зүйлсийг, өөрийн байран дээр цуглуулж ажиллана уу.

Цулуулсан эд зүйлсийг өдөрлөг болох газарт байгууллагууд тус бүрээс 1-2 албан хаагч авчран оролцоно уу.

Хавсралт 8 хуудастай

ДАРГА



Б.АМАРТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАСАГ ДАРГА ТӨСВИЙН ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 31 өдөр

А/65

Улаанбаатар хот

"Өгөөмөр өдөр" өдөрлөг зохион байгуулахад хөрөнгө зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх хэсэг, 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе" уриатай хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Ням гаригт 11:00 цагаас 17:00 цагийн хооронд Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадна талбайд зохион байгуулсугай.

2. "Өгөөмөр өдөр" өдөрлөгийн удирдамжийг нэгдүгээр, өдөрлөгт шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг оршин суугч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг идэвхтэй хамруулж ажиллахыг Хороодын Засаг дарга нарт, Орон сууц, Сууц өмчлөгчдийн холбоог уг өдөрлөгт идэвхтэй оролцуулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Б.Отгонхүү/-т үүрэг болгосугай.

4. "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Хэвлэл мэдээллийн алба /Т.Соёл-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Б.АМАРТҮВШИН

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын даргын 2019 оны  
05 дугаар сарын 21-ны өдрийн  
1/65 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## "ӨГӨӨМӨР ӨДӨР" ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Зорилго:** Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе" уриатай хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг зохион байгуулна.

**Хугацаа:** 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Ням гаригт /11:00 цагаас 17:00 цаг хүртэл/

### Ажил үүргийн хуваарь:

№	Байгууллагуудын нэр	Үүрэг оролцоо	Хяналт тавих хэлтэс
1	2	3	4
1	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	"Өгөөмөр өдөр" өдөрлөгт ажилчид албан хаагчдыг идэвхтэй хамруулах	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
	Дүүргийн Засаг даргын Тамгын газар дэргэдэх харьяа хэлтэс албад	"Өгөөмөр өдөр" өдөрлөгт идэвхтэй оролцох	
2	Хороод	1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг идэвхтэй оролцуулах, өдөрлөгийн талаарх мэдээллийг сурталчлан ажиллах, өөрийн байран дээр хуучин эд зүйлсээ /хүн хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин хувцас, гутал, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл гэх мэтийг угааж цэвэрлэн бэлдэн цуглуулж авах, хороо тус бүрээс төлөөлж нэгээс хоёр хүн өдөрлөгт оролцох	

1	2	3	4
3	Дүүргийн хөгжлийн төв	Орон сууц, Сууц өмчлөгчдийн холбоог идэвхтэй оролцуулах, сурталчлан ажиллах, өөрийн байран дээр хуучин эд зүйлсээ /хүн хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин хувцас, гутал, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл гэх мэтийг угааж цэвэрлэн бэлдэн цуглуулж авах, СӨХ бүрээс төлөөлж нэгээс хоёр хүн өдөрлөгт оролцох	

Хамаарах зүйлс: Гэр ахуйн бараа, тоглоом, ном, сурах бичиг,

**Тавигдах шаардлага:**

1. Угааж цэвэрлэсэн байх
2. Дахин ашиглаж болохуйц зүйлс

Утас 51-266579, 99278448 А.Монголжингоо



ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАРТ

**УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ц.Жигжиджавын гудамж 9, Хангарди ордон,  
Утас/Факс: (976-11) 31-53-47, <http://www.ubservice.mn>

2019.05.20 № 01/1195  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Хамтран ажиллах тухай

Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах, энэ талаархи иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөө" уриатай хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг 2019 оны 06 дугаар сарын 09-ний Ням гаригт 11:00 цагаас 17:00 цагийн хооронд иргэд олноор цуглардаг байршилд зохион байгуулахаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг зохион байгуулах тухай А/143 дугаар тушаал батлагдаад байна.

Иймд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч, өдөрлөгийн үйл ажиллагаанд байгууллагын ажилтан, албан хаагчдыг идэвхитэй оролцуулна уу.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалыг хавсаргав.

Хавсралт 4 хуудастай.

Хувийг: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, агентлагууд, Улаанбаатар хотын Захирагчийн харъяа газруудад

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  С.ГАНТӨМӨР



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 1143

Улаанбаатар хот


"Өгөөмөр өдөр" өдөрлөг зохион  
байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах, энэ талаархи иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе" уриатай хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг 2019 оны 06 дугаар сарын 09-ний Ням гаригт 11:00 цагаас 17:00 цагийн хооронд иргэд олноор цуглардаг байршилд зохион байгуулж, нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг идэвхтэй оролцуулахыг Дүүргүүдийн Засаг дарга нарт, өдөрлөгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, өдөрлөгийн талаархи мэдээллийг олон нийтэд сурталчилж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т тус тус даалгасгай.

2. "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Өдөрлөг зохион байгуулахтай холбоотойгоор байгууллагын ажилтан албан хаагчдын дунд хуучин эд зүйлсээ цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулж, өөрийн байгууллагын байршиж байгаа дүүргийн "Өгөөмөр өдөр" өдөрлөгт оролцохыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газруудын дарга нарт үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  КГАНТӨМӨР

1110300437

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 06 сарын 09 өдрийн  
АМТЗ-аар тушаалын хавсралт

**ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛАН ЯЛГАХ, БАГАСГАХ,  
БУУРУУЛАХ, ДАХИН АШИГЛАХ, ЭНЭ ТАЛААР ИРГЭДИЙН МЭДЛЭГ, ОРОЛЦООГ  
НЭМЭГДҮҮЛЭХ "ӨГӨӨМӨР ӨДӨР" ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН  
УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго.**

1.1 Улаанбаатар хотын иргэд өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгч дэмжлэг үзүүлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах, энэ талаар иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

**Хоёр. Хамрах хүрээ, хугацаа.**

2.1. Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Ням гаригт 11:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна.

**Гурав. Ерөнхий зохион байгуулагч.**

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

**Дөрөв. Хамтран зохион байгуулагч.**

- Хотын хөгжлийн дэмжих шинэ тосгон хөдөлгөөн ТББ
- Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал, хөгжлийн хүрээлэн ТББ
- Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ

**Тав. Аянд оролцогчид, зохион байгуулах үйл ажиллагаа**

№	5.1. Оролцогч байгууллага	5.2. Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл
1	Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс	Өдөрлөгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, өдөрлөгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчилж ажиллах, өдөрлөгийн үр дүнг Ерөнхий менежерт нэгтгэж тайлагнах Өгөөмөр өдөр аяны нэгдсэн лого, анонс хэвлүүлэх загварыг гаргана.
2	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газрууд	Байгууллагын ажилтан албан хаагчдын дунд хуучин эд зүйлсээ /хүн хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин хувцас, гутал, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл гэх мэтийг угааж цэвэрлэн бэлдсэн байх/ цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулж, өөрийн байгууллагын байршиж

		байгаа дүүргийн "Өгөөмөр өдөр" өдөрлөгт оролцох. Оролцооны талаарх мэдээ тайланг гаргаж Захирагчийн ажлын албаны ТХХУХ-т ирүүлэх
3	Дүүргүүдийн Засаг даргын тамгын газар	Аяны талаарх мэдээлэл, сурталчилгааг дүүргийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргэж, идэвхтэй оролцуулах, Захирагчийн ажлын албанаас гаргасан лого, анонсын загварын дагуу өдөрлөгийн анонсийг хэвлүүлж бэлтгэх Аяны нээлтийн ажиллагааг Дүүргийн иргэд олноор цуглардаг байршилд 11:00 цагт эхлүүлэх Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан албан хаагчдын дунд хуучин эд зүйлсээ /хүн хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин хувцас, гутал, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл гэх мэтийг угааж цэвэрлэн бэлдсэн байх/ цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулж "Өгөөмөр өдөр" өдөрлөгт оролцуулах. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын дүн мэдээг гаргаж Захирагчийн ажлын албаны ТХХУХ-т ирүүлэх
4	Хөндлөнгийн хяналтын ТББ-ууд	Дүүргүүдийн Өгөөмөр өдөр зохион байгуулах байршлыг дүүргүүдтэй хамтран тодорхойлж байршлын талаар нэгдсэн мэдээллийг нэгтгэн гаргах, Өдөрлөг болох байршил, зохион байгуулагдах үйл ажиллагааны мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилах Хариуцсан дүүргийн өгөөмөр өдөр өдөрлөгийн нээлтийн арга хэмжээг хамтран зохион байгуулах Хуучин эд зүйлс борлуулдаг ААНБ-уудтай хамтран ажиллаж оролцоог хангаж ажиллах.
5	Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо	Дүүргүүдийн заасан байршлуудад хоёрдогч түүхий эд худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулна.
6	Хувийн хэвшлийн аж ахуйн нэг байгууллага,	Байгууллагын ажилтан албан хаагчдын дунд хуучин эд зүйлсээ /хүн хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин хувцас, гутал, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл гэх мэтийг угааж цэвэрлэн бэлдсэн байх/ цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулж, өөрийн байгууллагын байршиж байгаа дүүргийн "Өгөөмөр өдөр" өдөрлөгт оролцох.
7	Иргэд	Өөрийн хуучин эд зүйлсээ /хүн хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин хувцас.



	гутал, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл гэх мэт/ угааж цэвэрлэн бэлдэж амьдарч байгаа дүүргийн "Өгөөмөр өдөр" өдөрлөгт оролцох. Өөрт хэрэгтэй байгаа эд зүйлсийг өгөөмөр өдөр өдөрлөгт оролцож худалдаж болон үнзгүй авах
--	--

**Зургаа : Аяны дүнг танилцуулах.**

- 6.1. Өгөөмөр өдөр өдөрлөгт оролцсон нийслэлийн төрийн захиргааны болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд байршиж байгаа дүүргийн Засаг даргын Тамгын газарт оролцооны талаар дүн мэдээг нэгтгэж 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 17:00 цагаас өмнө гаргаж өгнө.
- 6.2. Дүүргийн Засаг даргын Тамгын газар дүүргийн хэмжээний дүн мэдээг нэгтгэж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэст 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 18:00 цагаас өмнө гаргаж өгнө.
- 6.3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс дүүргүүдийн дүн мэдээг нэгтгэж 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Нийслэлийн Засаг даргын шуурхайд танилцуулна.